

## ТАНИЛЦУУЛГА

*“Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл,  
2025 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцох хүүгийн  
хэмжээг тогтоох тухай”*

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэгт “Даатгуулагчийн энэ хуулийн 29.2-т заасан мөнгөжүүлсэн орлогыг хассан нэрийн дансны эхний үлдэгдэл, бүртгэсэн шимтгэлийн орлогод жил бүр хүү тооцож, бүртгэнэ”, 27.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 27.6-д заасан тухайн жилийн хүүгийн хэмжээг дараах үзүүлэлтийг харгалзан хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн дараа оны нэгдүгээр улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно”, 27.7.1 дэх заалтад “өмнөх оны инфляцын түвшин”, 27.7.2 дахь заалтад “Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банкнаас албан ёсоор зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх жилийн дундаж хүүгийн хэмжээ”, 27.10 дахь хэсэгт “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж тус тус заасан.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны ээлжит хуралдаанаар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2023 оны эцсийн үлдэгдэл, 2024 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 11.34 хувиар баталсан бөгөөд 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн нийт 1,530.6 сая даатгуулагчдын 2023 оны эцсийн үлдэгдэл, 2024 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод 3,692.1 тэрбум төгрөгийн хүү тооцсон.

Нэрийн данс нээлгэсэн нийт 1,530.6 сая даатгуулагчаас 1979 оноос хойш төрсөн 1,180.8 сая даатгуулагч буюу 77.1 хувийг эзэлж байна.

Нэрийн дансны 2023 оны эцсийн үлдэгдэл, 2024 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцсон хүүгийн орлого 3,692.1 тэрбум төгрөгөөс 2,195.4 тэрбум төгрөг буюу 59.5 хувийг эзэлж байна.

Үзүүлэлт	Даатгуулагчийн тоо	Эхний үлдэгдэл	Хөдөлмөрийн хөлс	Шимтгэлд	ҮА зардал	Бүртгэсэн шимтгэл	Хүүгийн орлого		Эцсийн үлдэгдэл
							Эхний үлдэгдэл	Бүртгэсэн шимтгэл	
1960.01.01 ба түүнээс хойш төрсөн	1,530.6	29,388.7	22,988.0	3,495.6	132.1	3,169.3	3,332.7	359.4	36,250.2
Үүнээс: 1979.01.01 ба түүнээс хойш төрсөн	1,180.8	16,868.6	18,180.7	2,745.1	103.8	2,491.3	1,912.9	282.5	21,555.4

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Журам батлах тухай” 01 дүгээр тогтоолоор баталсан “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ын 5.2-т

заасан дараах томъёогоор нэрийн дансны хүүгийн хэмжээг тооцохоор баталсан.  
Үүнд:

$$X=A*I+B*D$$
$$A+B=1$$

Х - тухайн онд нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээ

И - өмнөх оны инфляцын түвшин;

Д - Банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3.1.20 дахь хэсэгт заасан арилжааны банкнаас албан ёсоор зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх оны жилийн дундаж хүүгийн хэмжээ;

А - инфляцын түвшингээс сонгох хувь хэмжээ;

Б - иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх оны жилийн дундаж хүүгийн хэмжээнээс сонгох хувь хэмжээ.

Дээрх хууль, журамд заасны дагуу 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш төрсөн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл, 2025 оны бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцох хүүгийн хэмжээг дараах үзүүлэлтүүдийг харгалзан тооцов.

#### 1. Инфляцын түвшин:

Үндэсний статистикийн хорооны [www.1212.mn](http://www.1212.mn) цахим хуудсанд байршуулсан мэдээгээр 2024, 2025 оны инфляцын түвшин тус тус дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	2024 он	2025
Инфляц, оны эцэст	9	7.5
Инфляц, жилийн дундаж	6.8	8.6

#### 2. Арилжааны банкуудын мөнгөн хадгаламжийн дундаж хүү:

Монгол банкнаас ирүүлсэн банкны системд нөлөө бүхий арилжааны 5 банкнаас зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн 2024 оны жилийн дундаж хүүгийн хэмжээг үндэслэн арилжааны банкуудын мөнгөн хадгаламжийн дундаж хүүг тооцоход 12.4 хувь байна. Үүнд:

Д/д	Банкны нэр	Төгрөгийн 1 жилийн хугацаатай хадгаламжийн 2024 оны хүүгийн хэмжээ
1	Хаан банк	12.85
2	Төрийн банк	12.54
3	Хас банк	10.94
4	Худалдаа хөгжлийн банк	13.26
5	Голомт банк	12.43
	Дундаж хүү	12.40

Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл, 2025 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцох хүүгийн хэмжээ

Дээрх үзүүлэлтүүдийг харгалзан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Журам батлах тухай” 01 дүгээр тогтоолоор баталсан “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ын 5.2-т заасан нэрийн дансны хүү тооцох томъёоны А хувьсагч буюу инфляцын түвшингээс сонгох хувь хэмжээг 0.2 байхаар, Б хувьсагч буюу иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх

оны жилийн дундаж хүүгийн хэмжээнээс сонгох хувь хэмжээг 0.8 байхаар тус тус тооцоход нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл, 2025 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцох хүүгийн хэмжээ 11.28 хувь байх тооцоолол гарч байна:

$$\text{Хүүгийн хэмжээ} = 0.2 \cdot 6.8 + 0.8 \cdot 12.4 = 11.28$$

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсэгт заасны дагуу холбогдох байгууллагуудаас санал авсан бөгөөд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл, 2025 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.28 хувь байхаар тооцсон тооцооллыг дэмжсэн, Үндэсний статистикийн хорооноос тооцоололд ашигласан 2024, 2025 оны инфляцын түвшний хэмжээ үнэн зөв байна, хүү тооцох аргачлалыг тодорхой болгох гэсэн саналыг тус тус ирүүлсэн болно.

Иймд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл, 2025 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.28 хувиар батлуулах саналтай байна.

---oOo---